

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Улаанбаатар хот

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн
санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн шалгалтын тухай

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сангийн сайдын 2018 оны 11дүгээр сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2018 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгалаа.

Шалгалтын дүнг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2012-2017 он, 2018 оны эхний 10 дугаар сарын байдлаар гаргасан тайлан, мэдээнд тулгуурлан холбогдох анхан шатны баримт болон санхүүгийн тайлангуудыгүндэслэн шалгалтыг хийлээ.

ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Шалгалтыг Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, санхүүгийн холбогдох заавар журам, Сангийн сайдын 253 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ыг удирдлага болгон хийв.

Санхүүгийн шалгалтыг явуулахдаа Засгийн газрын тогтоол, болон удирдах дээд байгууллагын даргын тушаал шийдвэр, холбогдох бусад эрхийн актуудыг үндэслэн сангийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл үр дүн, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэлд тусгасан байдал зэрэг санхүүгийн үйл ажиллагааг үндсэн баримт материалтай тулган шалгаж, холбогдох хүмүүстэй уулзан тодруулах замаар явуулсан болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2018 оны санхүүгийн үйл ажиллагааны төсвийн эрх захирагчийн гарын үсгийн нэгдүгээрийг Хөдөлмөрийн сайдын эрх олгосноор 2013.02.08-ны өдрийн А/26 тоот тушаалаар Санхүү, төрийн сангийн бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Наранцогт, 2015.02.12-ны өдрийн А/13 тоот тушаалаар М.Энх-Амар, гарын үсгийн хоёрдугаарыг тус газрын мэргэжилтэн Ц.Эрдэнэтөгс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайдын 2016.09.13-ны өдрийн А/84 тоот тушаалаар төсвийн эрх захирагчийн гарын үсгийн нэгдүгээрийг ХХҮЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нямдаваа, дээрх хугацаанд гарын үсгийн хоёрдугаарыг СЯ-тай зөвшилцсөний үндсэн дээр ерөнхий нягтлан бодогч Б.Нацагдорж, Хөдөлмөр ХХҮЕГ-ын даргын 2017.05.22-ны өдрийн б/88 тоот тушаалаар нягтлан бодогч Б.Оюунбилэг нар тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

САНГИЙН ЗОРИЛГО:

Сангийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулснаар энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна..

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН НЬ:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан ба уг хуулийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2011 онд байгуулагджээ. Тус сангийн үйл ажиллагааны зохицуулалттай холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулж, 2012, 2014, 2015, 2016, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар тусгай сан байгуулж, Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрөөс сангийн орлогыг бүрдүүлэхээр заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн удирдамжийг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэгдсэн төсвийг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын тушаалаар аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийн хуваарийг баталж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар тус сан нь өөрийн орлогоороо зарлагаа нөхөх зарчимаар ажиллаж, сангийн гол орлогоо гадаадаас Монгол Улсад ажиллаж байгаа иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогоос бүрдүүлж, зарлага нь улсын болон орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүйгээр ажилгүй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг байнгын болон түр ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлдэг Засгийн газрын тусгай сан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх олон төрлийн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулагдаж байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын зохион байгуулалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн талаархи төрийн

бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба нь улсын төсвөөс санхүүжинэ гэсний дагуу үйл ажиллагаагаа явуулж иржээ.

ХЭДСангийн байршлын судалгаа:

№	Утга	Батлагдсан он, сар өдөр	Дугаар	Тогтоолын нэр	Эрхлэх асуудлын хүрээ	Харьяа байгууллага	ХЭДСангийн байршил	ХЭДСанг хариуцсан огноо
1	МУ-ын Их хурлын тогтоол	2004.09.22	14	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ХХҮГ	2004-2008 он
2	МУ-ын Их хурлын тогтоол	2008.12.19	43	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ХХҮГ	2008-2012 он
3	МУ-ын Их хурлын тогтоол	2012.08.17	14	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Хөдөлмөрийн яам	ХЯам	2012-2016 он
4	МУ-ын Их хурлын тогтоол	2016.07.21	12	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	ХХҮЕГ	2016 оны 11-р сараас
5	МУЗГазрын тогтоол	2016.07.27	4	Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	МУЗГазрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 2-р хавсралтын 18-т Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	ХХҮЕГ	2016 оны 11-р сараас

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс 2017, 2018 онд хэрэгжүүлэхээр нийт 6 хөтөлбөр мөн жижиг зээл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр тус бүрийн зорилгуудыг хүснэгтээр харуулбал:

№	Хөтөлбөрийн нэр	Зорилго
1	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох	Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох сургалтанд хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах.
2	Ажлын байрыг дэмжих	Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэх
3	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэх
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх үр чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх үр чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх
6	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	Залуучууд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг аж ахуй, бизнес эрхлэх үр чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж ажлын байртай болгох
7	Жижиг зээл олгох арга хэмжээ:	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгох жижиг зээл нь өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, өргөтгөх, үйл ажиллагаагаа тогтвортой хадгалах, ажлын байр шинээр бий болгох

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2012 оноос туршилтын байдлаар, 2013 оноос Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд батлагдан хэрэгжиж эхэлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хөтөлбөр тус бүрээр авч үзвэл дараахи байдалтай байна. Үүнд:

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр

	ДИЙН ТОО	-ЖИЛТ								ХЭТЭР- СЭН		ХУВЬ
2017 ОН	267	805.5	805.5	*	*	28.9	127.3	165.1	340.0	35.4	585.0	20.5
2018 ОН 10.30	209	1,348.2	1,348.2	*	*	*	29.7	30.1	1,016.9	1.4	1,267.1	2.2
Нийт	476	2,153.7	2,153.7			28.9	157.0	195.3	1,356.9	36.8	1,852.2	11.3

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоол, 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоол, 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолуудаар “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр батлагдсан байна.

2013-2018 онуудад Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 13742 малчин хамрагдаж, 7752 ажлын байр бий болж 26,156,120.0 мянган төгрөг зарцуулсан, хэрэгжилт дунджаар 98 хувьтай байна.

- Малжуулах арга хэмжээнд 1175 малчин өрхийн 2916 малчин иргэн хамрагдаж 40404 хонь, 49350 ямаа 2127 үхэр 86 адуу худалдан авахад 5,300,177.0 мянган төгрөгийг;
- Аж ахуй эрхлэлт, мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага солилцох уулзалтанд 2260 өрхийн 3387 малчин иргэн хамрагдаж 361,964.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсанаар тайлагнасан байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэг, түүний эргэн төлөлт, үлдэгдлийн мэдээ

• /сая төгрөгөөр/

Он	Хамрагдсан иргэдийн тоо	Олгосон санхүүжилт	Эргэн төлөгдөх дүн	Төлсөн дүн						Үлдэгдэл			Нийт үлдэгдэл	Эргэн төлөлт-ийн хувь
				2014	2015 он	2016 он	2017 он	2018 он	Нийт	Хэвийн	хугацаа хэтэрсэн	Найдваргүй болсон		
2014	759	3,556.8	1,778.4	2.5	44.2	216.2	685.5	293.9	1,242.3	91.8	508.6	11.9	612.3	70
2015	1268	5,648.8	2,824.4		55.8	557.0	1,261.6	342.5	2,216.8	-1.1	736.3	7.0	742.2	79
2016	1031	4,370.3	2,185.1			78.8	593.0	881.8	1,553.6	349.2	345.2		694.5	71
2017	1028	4,470.6	4,470.6				155.3	902.4	1,057.8	2,627.8	99.6	4.0	2,731.4	24
2018.10.30	1090	4,891.9	2,446.0					29.7	29.7	4,858.1	6.1		4,864.2	2
Нийт	5176	228938.4	13704.5	2.5	100.0	852.0	2,695.4	2,450.3	6,100.2	7,925.8	1,695.8	22.9	9,644.6	49.2

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоол, 2015 оны 12 дугаар сарын 16-ны 09 дүгээр

тогтоолоор “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл”, 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолуудаар “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр” тус тус батлагдаж энэхүү хөтөлбөр, төслийн хэрэгжилт 2014, 2016-2018 онуудад дунджаар 92 хувьтай байна.

2014, 2016-2018 онуудад Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт нийт 8010 ахмад хамрагдаж 3,694,018.0 мянган төгрөг зарцуулж 3244 ажлын байр бий болжээ.

Ахмад настны эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэг, түүний эргэн төлөлт, үлдэгдлийн мэдээ талаар

/сая
төгрөгөөр/

Он	Хамрагдсан иргэдийн тоо	Олгосон санхүүжилт	Эргэн төлөгдөх дүн	Төлсөн дүн			Үлдэгдэл			Нийт үлдэгдэл	Эргэн төлөлтийн хувь
				2017 он	2018 он	Нийт	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Найдваргүй болсон		
2017	282	492.9	492.9	48.2	123.5	171.7	300.1	4.6	1.8	321.6	35
18.10.30	13	30	30		4.4	4.4	25.6			25.6	15
НИЙТ	295	522.9	522.9	48.2	127.9	1,76.1	325.7	4.6	1.8	347.2	25

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2012 онд туршилтын байдлаар Хувиараа болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолоор “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус баталсан байна. 2012-2018 онуудад Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт 93611 иргэн хамрагдаж 49,175,750.0 мянган төгрөгийг зарцуулж 57672 иргэн ажлын байраар хангагдсан, хэрэгжилт дундажаар 87.3 хувьтай байна.

Ажлын байрны дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэг, түүний эргэн төлөлт, үлдэгдлийн мэдээ

/сая төгрөгөөр/

Он	Хамрагдсан	Олгосон сан-	Эргэн төлөг	Төлсөн дүн	Үлдэгдэл	Нийт үлдэг	Эргэн төлөл-
----	------------	--------------	-------------	------------	----------	------------	--------------

	сан иргэдийн тоо	хүүжилт	дөх дүн	2015 он	2016 он	2017 он	2018 он	Нийт	Хэвийн	хугацаа хэтэрсэн	Найдваргүй болсон	дэл	тийн хувь
2015 он	2752	4,181.7	2,090.8	111.9	511.4	381.6	453.1	1,458.0	73.5	678.3	29.9	781.7	70
2017 он	2191	5,130.1	5,130.1	*	*	392.0	1,157.6	1,549.6	3,299.5	275.6	5.7	3,580.7	30
2018 он 10.30	1747	4,515.1	4,515.1	*	*	*	314.6	314.6	4,204.0	1.0		4205.0	7
Нийт	6690	13,826.9	11,736.0	111.9	511.4	773.6	1,925.3	3,322.0	7,577.0	954.9	35.6	8567.4	35,6

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоол, 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” тус тус батлагджээ.

2014-2018 онуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт 19714 иргэн хамрагдаж 12,976,712.0 мянган төгрөгийг зарцуулж 3059 иргэн ажлын байраар хангагдсан, хэрэгжилт дунджаар 95,4 хувьтай байна.

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ТАЛААР

Санхүүгийн дэмжлэгийг малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 35-с дээш хөдөлмөрийн насны иргэн, 18-34 насны залуучууд, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд зэрэг зорилтот бүлгийн иргэдийг хувиараа хөдөлмөр эрхлэх, өөртөө ажлын байр бий болгохыг нь дэмжин аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудаар дамжуулан шууд олгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хүснэгтээр харуулбал:

Он	Хөтөлбөрийн нэр	Арга хэмжээ	Эрх зүйн үндэслэл
2014	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд олгосон 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийг 3 жилийн хугацаанд эргэн төлөх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тавдугаар тогтоол
2015	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	Хувиараа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэнд олгосон 3,0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 50 хувийг 24 сарын дотор эргэн төлөх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн долдугаар тогтоол

	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд олгосон 4.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийг 24 сарын дотор эргэн төлөх Малчин өрхөд мал аж ахуйн багаж, тоног төхөөрөмж авахад олгосон 5,0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийг 2 жилийн хугацаанд эргэн төлөх	
2016	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд олгосон 4.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийг 24 сарын дотор эргэн төлөх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн есдүгээр тогтоол
2017	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэнд олгосон 3.0-5.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргэн төлөх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр тогтоол
	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан залуучуудын бүлэгт олгосон 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргэн төлөх, МБСБ-ийн төгсөгч, төгсөгчдийн бүлэгт олгосон 3.0-10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргэн төлөх	
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 4 жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх	
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд олгосон 4.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргэн төлөх	
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад иргэнд олгосон 3.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх	
2018	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэнд олгосон 3.0-5.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргэн төлөх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдүгээр тогтоол
	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан залуучуудын бүлэгт олгосон 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын дотор 100 хувь эргэн төлөх, МБСБ-ийн төгсөгч, төгсөгчдийн бүлэгт олгосон 3.0-10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын дотор 100 хувь эргэн төлөх	
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 4 жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн ажлын байр бий болгох аж ахуйн нэгжид олгосон 50.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөх	
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд олгосон 4.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын дотор 100 хувь эргэн төлөх	
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад иргэнд олгосон 3.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх	
			Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр тогтоол

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙГ АЙМАГ НИЙСЛЭЛ ДҮҮРГЭЭР АВЧ ҮЗВЭЛ:

/сая төгрөгөөр/

Он	Малчдын ХЭДХ		Ажлын байрыг ДХ		Залуучуудын ХЭДХ		Хөгжлийн БИАБДХ		Ахмад НАБХ	
	Олгосон	Үлдэгдэл	Олгосон	Үлдэгдэл	Олгосон	Үлдэгдэл	Олгосон	Үлдэгдэл	Олгосон	Үлдэгдэл
он										
Архангай	1037,0	543,7	459,0	261,0	93,0	71,7	98,0	84,9	30,0	21,5
Баян-Өлгий	891,0	540,7	389,5	268,1	25,0	21,1	76,0	69,4	25,0	21,1
Баянхонгор	1305,8	864,2	423,0	280,9	40,1	40,1	88,0	85,8	27,5	25,1
Булган	1151,0	410,7	339,0	194,0	41,0	36,0	70,5	67,1	22,0	18,2
Говь-Алтай	1090,9	363,4	336,0	130,3	84,0	64,5	66,5	45,6	19,5	13,3
Дорноговь	950,7	373,6	340,0	242,4	62,0	61,0	61,0	53,6	19,5	14,6
Дорнод	1336,0	677,7	478,5	304,2	153,0	141,8	98,0	87,1	40,0	30,6
Дундговь аймаг	885,0	294,1	186,0	145,0	39,0	15,1	65,0	56,7	19,5	14,5
Завхан	1180,2	598,4	510,0	383,7	121,0	112,6	101,0	97,5	25,0	23,5
Өвөрхангай	1995,6	582,6	612,0	322,9	67,5	54,9	104,0	96,5	26,5	19,0

Өмнөговь	1111,3	431,8	346,0	210,5	75,0	66,9	58,0	53,8	19,5	14,7
Сүхбаатар	957,9	412,0	309,0	139,2	51,0	43,2	79,0	67,7	19,5	4,2
Сэлэнгэ	1155,0	503,2	540,7	330,9	58,8	49,4	77,1	52,3	52,5	40,4
Төв	1371,0	490,0	612,1	339,8	31,0	20,7	89,0	76,5	25,0	17,6
Увс	1341,0	602,0	438,0	343,1	128,0	120,3	110,0	105,6	34,4	33,7
Ховд	1264,0	656,5	810,6	498,7	116,0	105,7	138,8	134,8	101,5	91,3
Хөвсгөл	1578,5	1159,7	800,5	473,5	145,0	133,6	106,0	102,1	30,5	26,2
Хэнтий	1268,4	574,3	550,0	368,7	80,0	73,1	109,0	101,1	31,0	24,6
Дархан-Уул аймаг	328,3	139,8	558,0	264,1	87,5	75,6	115,0	74,4	57,5	26,2
Орхон	251,7	77,5	555,5	248,6	77,0	63,2	94,0	75,6	25,0	15,7
Говьсүмбэр	177,4	13,6	193,0	71,8	22,0	21,1	34,0	26,7	8,5	6,5
Хан-Уул		0	476,0	264,9	36,0	30,0	289,0	239,2	86,0	57,4
Багануур дүүрэг	104,6	64,8	176,6	94,6	65,0	60,1	47,0	43,3	14,5	11,4
Баянзүрх	0	0	693,0	495,7	172,0	163,0	409,0	356,5	61,5	53,8
Налайх	149,0	115,5	282,0	151,4	30,0	19,1	75,0	11,3	19,5	13,4
БГД	0	0	535,4	296,3	120,0	107,0	282,3	248,4	55,5	41,0
СБД	0	0	630,6	392,0	66,0	62,1	302,0	248,4	52,5	33,8
Чингэлтэй дүүрэг	0	0	581,0	389,1	254,0	235,2	267,0	251,9	49,5	41,0
Багахангай дүүрэг	57,0	51,9	81,0	64,6	37,0	34,6	39,0	33,5	11,5	7,7
СХД	0	0	846,7	590,5	169,0	136,5	430,0	372,0	61,5	51,6
Нийслэлийн ХЭГ	0	0	0	0	0	0	0	0	0	0
ХНХСИ	0	0	0	0	0	0	0	0	0	0
ХХҮЕГ	0	0	0	0	0	0	0	0	0	0
	22938,3	10541,6	14088,6	8560,4	2545,9	2239,2	3978,2	3419,2	1071,4	813,3

/Жич: Хөтөлбөрүүдийн эргэн төлөлтийг дэлгэрэнгүй байдлаар Хавсралт 1-т харуулав./

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2017 онд хэрэгжүүлэх чиглэл, төслийн шалгаруулалт зохион байгуулах удирдамжийг тус тус баталсан байна.

Үүний дагуу Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/88 тоот тушаалаар дээрх төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж уг ажлын хэсэг “Хамгийн сайн” үнэлэгдсэн гэх 8 иргэн, 21 аж ахуйн нэгж байгууллыг сонгон шалгаруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/133, А/172 тоот тушаалуудаар батлуулан нэгж төслийн төсөвт өртгийг 200.0 хүртэл сая төгрөг байхаар нийт 3.986 тэрбум төгрөгний зээлийг **хүүгүй** олгосон байгаа нь Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.3.”Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлхэд зориулж үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг төсөлд 5.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд .../-т заасныг зөрчсөн байна.

Дээрх төслүүдийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар сонгон шалгаруулж, хэрэгжүүлсэн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.10-т заасныг баримтлаагүй, Төсвийн тухай хуулийн 6.4.5./төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;/-т заасныг зөрчсөн байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалуудад төслийн зээлийн нөхцөл, эргэн төлөлтийн хуваарь зэргийг батлаагүй зээл олгож зээлийн эргэн төлөлт 2018 оны 11 дүгээр сарын 29 өдрийн байдлаар хангалтгүй буюу 348.4 сая төгрөг байна.

Зээл авсан аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалтыг дэлгэрэнгүй байдлаар дор харуулав

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт

№	Аж ахуйн нэгж, иргэний нэр	Хуулийн этгээд эсэх	Төслийн нэр	Холбогдох этгээд	Олгогдсон санхүүгийн дэмжлэг	Санхүүгийн эргэн төлөлт 2018.01.01-2018.11.19	Үлдэгдэл
1	Мөнхийн залуу гоо үзэсгэлэн	ТББ	Кристина академи төсөл	Б.Тэмүүжин	200,000,000	600,000	199,400,000
2	Алтай Фүжи	ХХК	Хатад төсөл	Т.Мөнхбаяр	157,801,150	2,300,000	155,501,150
3	Т.Жаргалсайхан	Иргэн	Чип дизайн хөгжүүлэлтийн сургалтын төв байгуулах	Т.Жаргалсайхан	100,000,000	5,000,000	95,000,000
4	Сэрмүүн өнгө	ХХК	Хэвлэл, хаяг, реклам, бэлэг дурсгал	Ц.Чулуунцэцэг	50,000,000	200,000	49,800,000
5	Эгшиглэн магнай	ХХК	Хөгжмийн үйлдвэрийн хүчин чадал нэмэгдүүлэх	П.Байгалжав	50,000,000	1,000,000	49,000,000
6	ААНЦОМ	ХХК	Голланд стандартын хүлэмж жимс, ногоо	М.Сайханцэцэг	200,000,000	5,000,000	195,000,000
7	Монгол химикал	ХХК	Барилгын материалын үйлдвэр байгуулах төсөл	П.Баярсайхан	200,000,000	10,000,000	190,000,000
8	ЛЭЦ	ХХК	Үйлдвэрлэл өргөжүүлэх төсөл	Л.Солонго	158,000,000	4,000,000	154,000,000
9	Ч.Наранбаатар	Иргэн	Хог хаягдлын менежментийг сайжруулах, тээвэрлэлтийн зардлыг бууруулах	Ч.Наранбаатар	200,000,000	73,000,000	127,000,000
10	Б.Болорцэцэг	Иргэн	Хүрээ айл төсөл	Б.Болорцэцэг	40,000,000	2,305,000	37,695,000
11	Монгол сор хөгжил глобал академи	ТББ	Зөөлөн тоглоом болон даавуун эдлэлийн үйлдвэр/	Б.Даваасүрэн	200,000,000		200,000,000
12	Г.Атармаа	Иргэн	Ворк мн төсөл	Г.Атармаа	100,000,000	6,000,000	94,000,000
13	Б.Тамир	Иргэн	Фермерийн аж ахуй	Б.Тамир	150,000,000		150,000,000
14	Чандмань эрдэнийн нөхөд	Нөхөрлөл	Увсын чацаргана		150,000,000		150,000,000
15	Гэгээн гарц	ТББ	Ажлын байр амьдралын баталгаа төсөл	Ш.Отгонбаяр	80,000,000	1,200,000	78,800,000
16	Догсом трейд	ХХК	Сэлэнгэ сүрэг төсөл	Г.Баярцэнгэл	196,200,000	600,000	195,600,000
17	Ээж оюусайхан	ХХК	Авто засвар, авто угаалга, зоогийн газар	Б.Отгонбаяр	100,000,000		100,000,000

18	Жигүүр богд	ХХК	чацарганы үрээс тос боловсруулах үйлдвэрлэл	М.Мөнхбат	100,000,000	300,000	99,700,000
19	Өндөрхаан хот тохижилт	ОНТҮГ	Цэвэр цэмцгэр хот	Г.Баатар	120,000,000		120,000,000
20	Амин хэлхээ байгаль сан	Сан	Монгол говийн жимс	Б.Баярчимэг	123,998,850		123,998,850
21	Хатуу төмөр	ХХК	Таван эрдэнэ малын тэжээл үйлдвэрлэл	О.Эрдэнэ-Очир	150,000,000		150,000,000
22	Б.Цэцэгмаа	Иргэн	Сийрэг бетон блок үйлдэрлэл төсөл	Б.Цэцэгмаа	50,000,000	2,400,000	47,600,000
23	Алтан сүм	ХХК	Эрүүл хүнс	Ө.Наранхүү	150,000,000		150,000,000
24	М.Сарнайцэцэг	ХХК	Эко ааруул төсөл	М.Сарнайцэцэг	110,000,000		110,000,000
25	Хужирт таван эрдэнэ	ХХК	Био бордоо	Д.Цэвэлсүрэн,	150,000,000	40,000,000	110,000,000
26	Э.Мөнхтуул	Иргэн	Үр шим төсөл	Э.Мөнхтуул	200,000,000	2,500,000	197,500,000
27	АЗАТ	ХХК	Орон нутгийн мах, махан бүтээгдэхүүн	Х.Бердмурат	100,000,000	1,800,000	98,200,000
28	Дорнод Монголын нутгийн иргэдийн байгаль хамгаалах холбоо	ТББ	Ахмадын амралт сувилал, аялал жуулчлалын газар	Д.Дагвасүрэн	200,000,000	27,210,000	172,790,000
29	Дүнжингарав тур		Тэрэлж -Уул амралт төсөл		200,000,000	200,000,000	-
Нийт					3,986,000,000	385,415,000	3,600,585,000

ЖИЖИГ ЗЭЭЛИЙН ТАЛААР:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлн 12.1-д заасан арга хэмжээнүүдийг нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглүүлэн банкаар дамжуулан бичил бизнес эрхлэгчдэд ажлын байр бий болгоход зориулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаас жижиг зээл олгож байна. Жижиг зээлийг 2002 оноос олгож эхэлсэн бөгөөд 2011 он хүртэл банк болон санхүүгийн байгууллагаар буюу ББСБ-аар дамжуулан олгож ирсэн байна. Засгийн газрын тогтоолоор 2002 он, 2006 онуудад ХЭДС-гаас олгох жижиг зээлтэй холбоотой журам батлагдан мөрдөж ажилласан.


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга 2011 онд батлагдсанаар жижиг зээлийн журманд 2011 онд өөрчлөлт орж, 2012 оноос эхлэн зөвхөн банкаар дамжуулан жижиг зээл олгохоор болсон байна. Мөн Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт1. Жижиг зээлий нөхцөл

№	Нийгмийн зорилгот бүлэг	Жижиг зээлийн дээд хэмжээ /сая.төг/	Жижиг зээлийн нөхцөл
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	10.0	Жилийн хүү: 7.2% – 8.4% Хугацаа: 24 сар
2	Аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгч	20.0	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх: 6 хүртэл сар Барьцаа: 60 хүртэл хувьд багцын батлан даалттай /IFAD Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл/

Жижиг зээлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2-т заасны дагуу банкаар дамжуулан олгохоор заасан бөгөөд оролцогч банкуудын сонгон шалгаруулалтыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ) дээр сайдын тушаалаар үнэлгээний хороо байгуулан зохион байгуулж байна. Сонгон шалгаруулсан банкуудын мэдээллийг ХНХЯ-наас Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар (ХХҮЕГ)-т хүргүүлж, тус газар нь банкуудтай 30 сарын хугацаатай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Зураг1. ХЭДС-гаас жижиг зээл олгож буй схем



Жижиг зээлийг малчин, ажилгүй иргэн, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсүүдийн тодорхойлолтыг үндэслэн орон нутагт сумдын, нийслэлд дүүргийн оролцогч банкны салбаруудаар олгож байна.

Зээлийг олгохдоо банкны салбар нь аймаг, дүүргийн ХХҮХ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу үйлдвэрлэл үйлчилгээ эхлэн эрхлэх, түүнийгээ өргөжүүлэн ажлын байр шинээр бий болгох зорилгоор хувиараа болон өрхийн аж ахуй эрхлэх сонирхолтой иргэдийн төсөл ХХҮХ-ээр дэмжигдсэн тодорхойлолтыг үндэслэн банкны шалгуурыг хангаснаар жижиг зээлийг олгож байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах тухай” ХНХСайдын 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/280 дугаар тушаалын хавсралтаар жижиг зээлийн төсвийг аймаг, дүүргээр хуваарилах аргачлал,

банк сонгон шалгаруулах удирдамж, банктай байгуулах гэрээний загвар, жижиг зээлд хамрагдах хүсэлт гаргагчдыг сонгон шалгаруулах удирдамж, зээлийн өмнөх сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр, зардлыг жишиг болон жижиг зээл хүсэгчийн санал болгож буй бизнесийн төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлыг үнэлэх арга хэрэгслүүд зэрэг батлагдсан байна.

2017-2018 онд Голомт, Төрийн банк, Хаан банкуудын салбаруудаар дамжуулан жижиг зээл олгож байна.

№	Жижиг зээл олгож буй банк	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ дуусах хугацаа	Байршуулсан эх үүсвэр /сая.төг/	Эх үүсвэр ашиглалт /2018.09.30/	Хугацаа	Үлдэгдэл тооцох хүү
1	Капитал дууссан/ /хугацаа	2015.09.23	2018.03.23	7,000.0	3,580.0	30 сар	3%
2	Голомт	2017.02.10	2019.09.10	20,000.0	20,000.0	30 сар	3%
3	Хаан банк	2018.08.15	2021.02.15	9,000.0	880.7	30 сар	3%
4	Төрийн банк	2018.08.15	2021.02.15	6,900.0	630.3	30 сар	3%

ХЭДС-аас дамжуулан зээлдүүлэх зээлийн судалгаа 2002-2018, түүний үр дүнгийн талаар:

- 2002-2012 онуудад олгосон жижиг зээл

Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам”-ын хүрээнд жижиг зээл олгох үйл ажиллагааг банк, санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгож ирсэн байна. Уг журмыг Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”-аар шинэчлэн батлагдсан.

Жижиг зээлийг Хас, Интер, Голомт, Анод, Монгол Шуудан, Капитал, Хаан банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгож байжээ. Эдгээр банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан нийт 58.8 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг зээлдэгчдэд олгосон байна. Зээлд нийт 37,540 иргэн, ААН хамрагдсан бөгөөд шинээр болон хадгалагдсан 94,718 ажлын байр бий болгожээ.

Хугацаа	Байршуулсан хөрөнгө мян.төг	Буцаан төвлөрүүлсэн	Үлдэгдэл	Зарцуулсан хөрөнгө мян.төг	Эх үүсвэр ашиглалт	Хамрагдсан иргэн, ААН	Бий болгосон ажлын байр
2002	570,000.0	570,000.0	-	480,140.0	84.24%	406	1,221
2003				1,801,900.0		1512	3,648
2004				2,865,800.0		3029	6,333
2005	2,880,000.0	2,880,000.0	-	1,930,661.9	67.04%	1156	2,689
2006				3,537,925.5		1465	7,159
2007	7,880,000.0	7,880,000.0	-	7,832,250.0	99.39%	5,926	16,658
2008	9,379,943.0	8,500,000.0	800,000.0	13,692,567.5	145.98%	8190	21,978
2009	9,000,000.0	9,000,000.0	-	7,425,233.6	82.50%	4862	10,856
2010	7,100,000.0	7,100,000.0	-	11,868,735.0	167.17%	7,178	15,877
2011	7,000,000.0	7,000,000.0	-	7,150,524.0	102.15%	3,816	8,299
Нийт	43,809,943.0	42,930,000.0	800,000.0	58,585,737.6		37,540.0	94,718.0

ХЭДС-гаас 2008 онд Анод банкаар дамжуулан олгосон жижиг зээлийн эх үүсвэр

эргэн төлөгдөөгүй байна. Тухайн үед Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас тус банкинд Монголбанкнаас томилогдсон эрх хүлээн авагчид хандаж, зээлийн эх үүсвэрийг буцаан татах талаар удаа дараа албан бичиг хүргүүлж байсан ч шийдвэрлэгдээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2012-2018 онуудад олгосон жижиг зээлийн судалгаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга 2011 онд батлагдсанаар Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам” шинэчлэн батлагдсан. Уг журмын дагуу өмнө нь Банк бус санхүүгийн байгууллагаар олгож байсныг болиулж, зөвхөн банкаар дамжуулан жижиг зээл олгохоор заасан. Мөн Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам" дахин шинэчлэн батлагдсан байна.

2012 оноос хойш 5 арилжааны банкаар дамжуулан нийт 93.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршуулж, 71.2 тэрбум төгрөгийн зээлийг зээлдэгч иргэд, ААН-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор олгосон. Зээлийн эргэн төлөлт 35.2 тэрбум төгрөг төлөгдөж, төлөгдөөгүй үндсэн зээл 58.7 тэрбум төгрөг байна.

/сая төгрөгөөр/

Он	Төсөв	Гүйцэтгэл	Эргэн төлөлт	Төлөгдөөгүй зээл	Тайлбар
2012	-	-	-	-	2012 онд жижиг зээлэнд мөнгө олгоогүй
2013	30,000.0	30,000.0	14,180.1	15,819.9	Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын дагуу Хөдөлмөрийн яам болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /хуучин нэрээр/-ны хооронд Дамжуулан зээлдүүлэх гэрээ" байгуулж 17,000.0 сая төгрөгийн зээл олгосноос үндсэн зээлийн төлбөрт 1,180.1 сая төгрөг төлж, 15,819.9 сая төгрөгийн үндсэн зээл төлөгдөөгүй байна. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүд арилжааны банкуудтай гэрээ байгуулан 13,000.0 сая төгрөгийн зээл олгосон ба эргэн төлөлт хийгдсэн байна.
2014	17,000.0	17,000.0	17,000.0	-	Төрийн банкинд 17,000.0 сая төгрөгийн зээл олгосон ба эргэн төлөгдсөн.
2015	13,000.0	11,000.0	4,000.0	7,000.0	Төрийн банкинд 4,000.0 сая төгрөгийн зээл олгосон ба эргэн төлөгдсөн, Капитал банкинд 7,000.0 сая төгрөгийн зээл олгосон эргэн төлөх хугацаа болсон боловч эргэн төлөөгүй байна
2016	13,000.0				2016 онд жижиг зээлэнд мөнгө олгоогүй
2017	13,000.0	20,000.0		20,000.0	Голомт банкинд 20,000.0 сая төгрөг жижиг зээл олгосон, 2019 онд эргэн төлөгдөнө.
2018	22,900.0	15,900.0		15,900.0	Төрийн банкинд 6,900.0, ХААН банкинд 9,000.0 сая төгрөгийн жижиг зээл олгосон, 2021 онд эргэн төлөгдөнө.
Нийт	108,900.0	93,900.0	35,180.1	58,719.9	

Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын дагуу Хөдөлмөрийн яам болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /хуучин нэрээр/-ны хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ" байгуулж 17,000.0 сая төгрөгийн зээл олгосноос үндсэн зээлийн төлбөрт 1,180.1 сая төгрөг төлж, 15,819.9 сая төгрөгийн үндсэн зээл төлөгдөөгүй байна. Аймаг,

дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүд арилжааны банкуудтай гэрээ байгуулан 13,000.0 сая төгрөгийн зээл олгосон ба эргэн төлөлт хийгдсэн байна.

Голомт, Калитал, Төрийн банк, Хаан банкуудад олгосон зээлүүдээс Калитал, банкны 7,000.0 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөөгүй байна.

Зээлийн эх үүсвэрт байршуулсан хөрөнгө, түүний ашиглалт 75.8 хувь буюу 71.2 тэрбум төгрөгийг эцсийн зээлдэгчдэд олгосон байна.

№	Он	Зээлийн дүн Нийт	Зээлд хамрагдсан			Батлан даалт		Хүүгийн хөнгөлөлт		Банк	Чанаргүй зээл	
			иргэн	ААН	нөхөрлөл	тоо	дүн	тоо	дүн		тоо	дүн
1	2012	15,464,064.6	6,020	50	48	-	-	121	19,147.8	Төрийн, Хаан, Капитал	28	123,500.0
2	2013	9,115,713.4	2,598	16	47	1	500.0	68	12,711.3	Төрийн, Хас, Хаан, Капитал	34	140,000.0
3	2014	15,653,670.5	4,434	18	79	6	23,000.0	55	8,733.5	Төрийн, Хас, Хаан, Капитал	21	98,600.0
4	2015	5,367,559.0	1,425	3	37	213	574,860.0	1	123.1	Төрийн, Капитал	7	21,500.0
5	2016	4,114,476.5	945	7	69	217	622,095.0	-	-	Төрийн, Капитал	3	16,000.0
6	2017	12,008,450.0	841	200	71	48	312,700.0	-	-	Голомт	5	20,125.8
7	2018-09	7,991,550.0	542	188	36	130	953,200.0	-	-	Голомт	5	49,466.0
		1,511,000.0	142	17	5			-	-	Хаан, Төрийн		
Нийт		71,226,484.0	16,947	499	392	615	2,486,355.0	245	40,715.7		103	469,191.8

САНГИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Тус сангаас 2012-2017 онд 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд нийт 35 төсөл арга хэмжээнд 875,309 хүнийг хамруулж 482.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,307,191 хүнд 375.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож төсөвлөсөн зардлаас 106.4 тэрбум төгрөгийг хэмнэсэн тооцоо гарч байгаа боловч төсөлд хамрагдсан хүний тоо 431,882 хүнээр илүү байна.

Сангийн гол орлого гадаадаас Монгол Улсад ажиллаж байгаа иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогоос бүрдэж байна, зарлага нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх олон төрлийн үйлчилгээ, арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2018 оны орлого, зарлагын төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

Он	Орлого			Зарлага		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
2012	59,713.3	60,838.9	102%	59,713.3	48,481.9	81%
2013	87,400.0	70,374.6	81%	87,400.0	79,490.6	91%
2014	87,400.0	55,929.1	64%	87,400.0	65,424.3	75%
2015	70,355.9	56,607.2	80%	70,355.9	53,357.2	76%

2016	50,281.9	33,040.8	66%	50,281.9	34,916.7	69%
2017	61,498.0	51,607.4	84%	61,498.0	53,247.0	87%
2018.10.30	65,348.0	74,024.1	113%	65,348.0	40,652.2	62%
Нийт	481,997.1	402,422.1	84%	481,997.1	375,569.9	77%

Энэ нь төсөл хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдийн хүссэн санхүүжилтийг үндэслэлгүйгээр бууруулан олгодог байдал нийтлэг байгаагаас шалтгаалж тухайн жилд батлагдсан төсвийг аль болох олон хүнд хүртээж хамруулах гэсэн бодлого мэт харагдаж байгаа боловч эргээд төслийг үр дүнгүй болгох, хэрэгжихгүй байх шалтгаан нөхцлийг бүрдүүлжээ.

ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгийн эх үүсвэрээс бүрдэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2012-2017 он, 2018 оны эхний 10 сарын байдлаар нийт 564.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцож, гүйцэтгэлээр 551.2 тэрбум төгрөгийн орлогыг Улс, орон нутгийн төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлого, бусад эх үүсвэрээс төвлөрүүлсэн байна.

2012 оноос хойш улс орны эдийн засгийн нөхцөл байдал, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор сангийн орлогод уг орлогын эзлэх хувь хэмжээ буурах хандлагатай байгаа ч 2005-2016 онд улсын болон орон нутгийн төсвөөс тус санд хөрөнгө хуваарилагдаагүй ба 2018 онд улсын төсвөөс 3,850.0 сая төгрөг хуваарилсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2018 оны орлогын төрлөөр

Хүснэгт 2

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018 10.30
1	Улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө							3,850.0
2	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр	53,466.7	47,072.0	53,242.1	43,059.4	32,592.6	29,704.5	19,906.3
3	Жижиг зээлийн эргэн төлөлт	7,000.0	22,322.3	2,069.0	12,957.7	-	17,000.0	4,000.0
4	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	291.4	392.6	563.4	447.3	448.1	1,012.2	860.2
5	Бусад	80.7	587.7	54.6	142.8		3,890.7	6,063.7

6	Урьд оны үлдэгдэл							39,244.0
	Орлогын дүн	60,838.8	70,374.6	55,929.1	56,607.2	33,040.8	51,607.4	74,024.2

Гэвч сангийн мэдээллийн нэгдсэн баазыг бүрдүүлээгүйгээс шалтгаалж төсөл хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлийг он тус бүрээр үнэн зөв тооцох боломжгүй байна. Иймд тус байгууллагаас гаргасан судалгааны дүнд үндэслэн боломжтой хувилбараар нэгтгэсэн дүнг харуулав.

2005-2012 онуудад тус сангийн зарлагын 57.8 хувийг мэргэжлийн сургалт, нийтийг хамарсан ажил, ажил олгогчийг дэмжих арга хэмжээ, жижиг зээлд зарцуулж байсан бол сүүлийн 5 жилд сангийн зарлагын 70 хүртэл хувийг шинээр төсөл, хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулсны дотор жижиг зээлд зарцуулах хөрөнгийн хэмжээ өсөх хандлагатай байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сумын иргэдэд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор 2012-2014 онуудад Сум хөгжүүлэх санд 60.0 тэрбум төгрөг, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад амьжиргааны тэтгэлэг олгох зорилгоор 2015-2016 онуудад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд 21.4 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

2012-2018 онуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд жилд төвлөрүүлсэн хөрөнгийн 60-90 хувийг тухайн жилдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж ирсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт /үйл ажиллагааны төрлөөр/

Хүснэгт 3

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018.10. 30
1	Жижиг зээлд зарцуулсан хөрөнгө	7,546.7	30,000.0	17,858.3	11,000.0	-	20,000.0	15,900.0
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд	16,935.1	25,490.5	35,565.7	31,105.9	24,767.4	33,247.0	24,752.2
3	Сум хөгжүүлэх санд	24,000.0	24,000.0	12,000.0	-	-		
4	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд	-	-	-	11,251.3	10,149.3		
	Зарцуулалтын дүн	48,481.8	79,490.5	65,424.0	53,357.2	34,916.7	53,247.0	40,652.2

САНГИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ТАЛААР

2017 оны санхүүгийн тайланд тусдсанаар тайлант хугацааны эхэнд 97.2 тэрбум төгрөгийн авлагатай байсан бол энэ дүн 77.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнээс 63.3 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулсанаар 111.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2012-2017 оны хооронд үүссэн авлагын дүнгээс харахад жилийн 2017 оны жилийн эцсийн байдлаар төрийн санд татан төвлөрүүлсэн санхүүжилтийн 40.8 тэрбум, хувийн хэвшлийн аж ауйн нэгжүүдэд Төрийн Банк, Капитал банкаар дамжуулан олгосон жижиг зээл, Үйлдвэр, худалдааны яамаар дамжуулан зээлдэх нөхцөлөөр хувийн хэвшлийн аж ауйн нэгжүүдэд олгосон нийт 44.7 тэрбум төгрөгийн авлагатайгаар тайлагнасан байна.

Авлагын үзүүлэлт 2017.12.30-ны байдлаар

/сая төгрөгөөр/

№	Нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
	НИЙТ ДҮН	97179,8	77757,8	63311,9	111625,6
1	Татаас, санхүүжилтийн авлага	40883,6	39244,0	40883,6	39244,0
2	Зээлийн хүүгийн авлага	,6	,0	,6	
3	Байгууллагаас авах авлага	2757,2	87,1	2,3	2841,9
4	Хувь хүмүүсээс авах авлага	456,4	950,3	267,0	1139,6
5	Хувь хүмүүст олгосон зээл		33,0	5,6	27,4
6	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	44746,4	20000,0	17000,0	47746,4
7	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	2,3		2,3	
8	Ажилд зуучлах	,5		,3	,3
9	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний дэмжих	1411,6	5026,0	860,5	5577,1
10	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	22,3	290,0	52,8	259,6
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		1742,3	99,7	1642,6
12	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	5554,5	4687,5	2716,8	7525,2
13	Засгийн газар, ХЭҮЗ бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	1308,7	4790,3	1319,5	4779,6
14	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	1,2		1,2	
15	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	3,5		3,5	
16	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл		2,3	2,3	
17	Нийтийг хамарсан ажил	30,8		30,8	
18	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ		358,5	43,5	315,0
19	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих		546,5	19,7	526,8

2017 оны санхүүгийн тайланд тусдсанаар тайлант хугацааны эхэнд 2.6 тэрбум

төгрөгийн өглөгтэй байсан бол энэ дүн 10.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнээс 12.5 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулсанаар 270.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна

Өглөгийн үзүүлэлт үзүүлэлт 2017.12.30-ны байдлаар

№	Үзүүлэлт	/сая төгрөг/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
НИЙТ ДҮН		2596,9	10221,2	12548,1	270,0
1	Цалингийн өглөг		2,0	2,0	
2	НДШ-ийн өглөг		1,8	1,8	
3	ХАОАТ-ын өглөг	54,4	52,9	106,3	1,0
4	Бусад зардлын өглөг		7,1	7,1	
5	Зээлийн хүүгийн өглөг	,6	,3	1,0	
6	Байгууллагад төлөх өглөг	1002,6	3550,9	4323,2	230,3
7	Хувь хүмүүст төлөх өглөг	368,6	222,8	586,6	4,8
8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	7,1	71,4	77,7	,8
9	Ажилд зуучлах	,7	55,7	56,4	
10	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэний дэмжих	99,9	1364,1	1461,7	2,4
11	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах	173,8	543,2	703,2	13,8
12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	15,5	307,5	322,8	,1
13	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	449,4	870,5	1315,9	4,0
14	Засгийн газар, ХЭҮЗ, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	292,3	1386,3	1668,0	10,6
13	Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалт	,2	62,2	62,4	
14	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	3,7	11,2	14,9	
15	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	3,2	114,2	117,4	
16	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	1,0	29,1	30,1	
17	Хөдөлмөрийн харилцаа, үндсэн эрхийн хэрэгжилт	2,8	50,8	53,3	,3
18	Хөтөлбөр, төслийн хяналт үнэлгээ	6,5	61,1	67,6	
19	Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа		5,0	5,0	
20	Гарын авлага, хэвлэмэл материал	2,3	25,3	27,6	
21	Нийтийг хамарсан ажил	112,1	1127,5	1237,9	1,7
22	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ		227,9	227,9	
23	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих		70,3	70,3	

Өглөгийн дүнгээс харахад: байгууллагад төлөх өглөг 4.2 тэрбум, хувь хүмүүст төлөх өглөг 586.6 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлт, Засгийн газар, ХЭҮЗ, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийтийг хамарсан ажлын санхүүжилттэй холбогдсон төсөл арга хэмжээний хүрээнд үүссэн өглөг харьцангуй буурсан байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН НИЙТЛЭГ ЗӨРЧЛИЙН ТАЛААР

- **Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах, орлого тасарч байгаа шалтгааныг судлан, төлөвлөлтийг оновчтой болгох талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулаагүй байна.**

Тухайн байгууллага "Төсвийн тухай" хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-ийн "улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал, Сангийн хөрөнгө төвлөрүүлэлт 2013 онд 7.9 тэрбум төгрөгөөр тасалдсан, аж ахуйн нэгж, байгууллагууд Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолд заасан "Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийг сар бүр төлөх" заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 3 тэрбум төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлээгүй байгаа нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн дайчлан ажиллах талаар анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Ажиллах хүч гадаад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг төлнө", 9.6-д "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг Засгийн газар тогтооно." гэж заасны дагуу Засгийн газрын тогтоолуудаар ажлын байрны төлбөрийг чөлөөлж иржээ.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 2012-2018 онд Квотоос чөлөөлсөн хүний тоо 169510, ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн хүний тоо 20342 болж нийт 30.4 тэрбум төгрөгийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн нь энэ хэмжээний орлого санд төвлөрөх боломжийг алдсан байна.

- **Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн зээлийг хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болгож зээл олгохдоо Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн хэмжээг хэтрүүлэн олгосон байна.**

▪

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2017 онд хэрэгжүүлэх чиглэл, төслийн шалгаруулалт зохион байгуулах удирдамжийг баталсаны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/133, А/172 тоот тушаалуудаар нэгж төслийн төсөвт өртгийг 200.0 хүртэл сая төгрөг байхаар тооцож нийт 3,986 тэрбум төгрөгний зээлийг 8 иргэн, 21 аж ахуйн нэгжид **хүүгүй** олгосон нь "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлхэд зориулж үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг төсөлд 5.0 сая хүртэл

төгрөг байх ...” Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.3-д заасныг тус тус зөрчсөн байна.

- ***Капитал банкинд байршуулсан 7.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хугацаанд нь буцаан төвлөрүүлээгүй, хугацаа хэтрүүлсэний алданги тооцож төлүүлээгүй байна.***

Хөдөлмөрийн сайд болон Капитал банк хооронд 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 2015/65 5/342 дугаартай гэрээг байгуулж, жижиг зээл олгоход зориулж 7.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр банкинд байршуулсан байна. Гэрээний хугацаа 2018 оны 3 дугаар сарын 23-нд дуусч, эх үүсвэрийг буцаан төвлөрүүлэх ёстой байсан хэдий ч одоог хүртэл төвлөрүүлээгүй байна.

Дээрх эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй, зээлд ашигласан дүн нь 3.58 тэрбум төгрөг буюу 51.1 хувь байгаа нь үлдэх эх үүсвэрийг банк зориулалт бусаар ашигласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн зээлийн эх үүсвэрийг гэрээний дагуу 6 сарын дотор бүрэн зээлд гаргаж дуусгах, үүнээс хойш ашиглаагүй эх үүсвэрт сарын 0.3 хувийн алданги тооцохоор заасан боловч ХЭДС-нд төлөх ёстой алдангийг тооцож төлүүлээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж тооцоо хийж баталгаажуулаагүй байна.

- ***Дампуурсан “Анод” банк болон “Дэлгэр Экспресс” ББСБ-аас авах найдваргүй авлагын үлдэгдэл 847.5 сая төгрөг балансад бүртгэлтэй байна.***

2005-2008 онд Анод банкаар дамжуулан ХЭДСан нь жижиг зээл олгож байсан бөгөөд тус банк татан буугдсанаар 2008 онд байршуулсан эх үүсвэрийн үлдэгдэл 800 сая төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй байна.

Мөн “Дэлгэр Экспресс” ББСБ-аар дамжуулан олгож байсан жижиг зээлийн эх үүсвэр 47.5 сая төгрөгийг буцаан татан төвлөрүүлээгүй, найдваргүй авлага хэлбэрээр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

- ***Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын дагуу ХЭДС-гаас олгосон 17.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн эргэн төлөлт хангалтгүй, хуульд заасан зардлын ангилалаас гаргаагүй, Сангийн яамны 2017 оны шалгалтын ажлын хэсгээс гаргасан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.***

Уг тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн дүрэмт хувцыг үндэсний үйлдвэрүүдээс нийлүүлэх зорилгоор Хөдөлмөрийн яам болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /хуучин нэрээр/-ны хооронд “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” байгуулж, “Оёдлын нэгдсэн холбоо” ТББ-д ХЭДС-гаас 17.0 тэрбум төгрөг олгосон нь Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг зээлийг зөвхөн банкаар дамжуулан олгох” -оор заасан журмыг зөрчсөн байна.

Мөн уг эх үүсвэрийг гаргахдаа хуульд заасан зардлын төрлөөр бус тухайн оны жижиг зээлд батлагдсан төсвөөс зарцуулсан байна. “Оёдлын нэгдсэн холбоо” ТББ-д олгосон зээлээс 1,180.1 сая төгрөг төлж, 15,819.9 сая төгрөгийн үндсэн зээл төлөгдөөгүй байна. Сангийн яамны СХЭУГ-аас 2017 онд ХЭДС-гийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтээр уг зээлтэй холбоотой үндсэн зээлийн үлдэгдэл, хүү болон алдангийн төлбөр болох нийт 18.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулж зээлийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн боловч биелэлт үр дүн хангалтгүй байна.

- **Төсөл сонгон шалгаруулалт явуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг зөрчиж** “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжигдэх 20 төсөлд 2,286.8 сая төгрөг, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/107 тоот тушаалаар ажлын хэсгийн зөвлөмжийг үндэслэн нэмж жагсаалтаар олгосон 4 төслийн 390.0 сая төгрөг нийт 2,676.8 сая төгрөгийн ажлыг Хөдөлмөрийн яамаар дамжуулан 23 ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч гэрээний биелэлт үр дүнг тооцоогүй байгаа нь “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 6.4.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэснийг зөрчсөн байна.
- **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийг зөрчиж** хөдөлмөрийн яамны ажиллагсадын томилолтын зардалд 178.4 сая, Солонгос улсад ажиллаж амьдарч байгаа иргэдэд зориулсан өдөрлөг болон бусад арга хэмжээний зардалд 200.3 сая, уулзалт хэлэлцээр, үйлчилгээний зардалд 27.0 сая нийт 505.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан боловч холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна.
- Системийн хэмжээгээр олгогдсон жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарь, гэрээний хугацаанд тавих хяналт муугаас хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үлдэгдэл ихтэй байгаагаас авлага үүссэн, орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн сонгон шалгаруулалтад шалгарсан зарим төслүүд нь шалгуур үзүүлэлт хангаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасныг тус тус зөрчсөн байна.
- **Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/152 дугаар тушаалаар жижиг зээлийн эх үүсвэрийг аймаг, дүүргийн дэд сангуудад хуваарилсан ба арилжааны банкуудтай гэрээ байгуулсан байна. Эдгээр оролцогч банкуудын сонгон шалгаруулалт явагдсан эсэх талаар холбогдох баримт байхгүй, зээлийн ашиглалт хангалтгүй, түүнд тавих хяналт сул байна.**

- Оролцогч банкууд болох Хас, Хаан, Капитал, Төрийн банкуудтай Хөдөлмөрийн сайд болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсийн дарга нарын хооронд гэрээ байгуулсан боловч эдгээр банкуудыг хэрхэн сонгон шалгаруулсан эсэх талаар баримт материал хангалтгүй байна. Зээл авах хүсэлтийг хичнээн иргэн ирүүлсэнээс хэдэн хүнд зээл олгосон талаар нэгдсэн судалгаа байхгүй байна.

Жижиг зээлийн эх үүсвэр байршуулахдаа банкны сонгон шалгаруулалтыг зарлалгүй Хөдөлмөрийн сайд, Төрийн банкны Гүйцэтгэх захирлын хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шууд гэрээ байгуулан 17.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байршуулсан байна.

Жижиг зээл олгож буй банкуудтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээнд ХХҮЕГ зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавихаар заасан ч хэрэгжилт хангалтгүй, зээлийн ашиглалтад тавих хяналт сул байна. Мөн Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын 6.5-д зааснаар аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс жижиг зээлийн эх үүсвэрийн ашиглалт, зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих байдал хангалтгүй байна.

- **Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгогдож байсан санхүүгийн дэмжлэгийг буцалтгүй тусламж болгон өөрчилсөн, ажлын байрыг дэмжих, аж ахуй, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн муутай байна.**

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2015 оны 02 сарын 12-ны тогтоолоор Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн 50 хувийг 24 сарын дотор эргэн төлөх нөхцөл мөрдөгдөж байсныг 2015 оны 12 сарын 16-ны тогтоолоор Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр болгон санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөхөөргүй болгон өөрчилсөнөөр 3.9 тэрбум төгрөгийг буцалтгүй байдлаар олгосон байна. Харин 2017 оны 1 сарын 27-ны өдрийн тогтоолоор энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгож буй дэмжлэгүүдийг 100 хувь эргэн төлөхөөр зохицуулсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр нь ЕБС-ын хүүхдүүдээс хэдэн хүүхэд мэргэжлээ зөв сонгож байгаа эсэх тодорхойгүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, эргэх холбоо сул, үр дүн, үр нөлөө багатай гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Сургуулийн сурагчдад ерөнхий боловсролын сургуулийн программд орсон хичээлээр багштай хамтран хичээл заах төслийг шалгаруулж санхүүжүүлсэн нь Хөдөлмөрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлагдсан Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх ажлын удирдамжийн 3.10-ын “Төслийн 4.2-т тусгагдсан хүүхдийн

хөдөлмөр зуслан, урлаг, спортын онцлог төрөл мэргэжлийн дугуйлан ажиллуулахад Хөдөлмөрийн хуулийн 109 дүгээр зүйлд заасныг ойлгож хэрэгжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг орон нутгийн харъяалалгүй гадны байгууллага зохион байгуулж явуулж байгаагаас шалтгаалж сургалтын чанар муу, богино хугацаанд хичээллэж эргэх холбоогүй байгаагаас шалтгаалж гүйцэтгэл үр дүн, бодитой тооцогдоггүй,

Мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөр, модулиас шалтгаалан сургалтын үргэлжлэх хугацааны талаар тодорхой мэдээлэл хөтөлбөрт болон удирдамжинд тусгагдаж ирдэггүйгээс сургалтын үргэлжлэх хугацаа тодорхойгүй, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад энэ талаар мэдээлээгүй, сургалтад хамрагдаж буй иргэдийг чадавхижуулах, мэргэшүүлэх талаар Бизнес инкубацийн үйлчилгээ орон нутагт байдаггүйгээс сургалт үр дүнгүй болж хөрөнгө мөнгийг үр ашиггүй зарцуулах үндэслэл болж байна.

Сургалтын эрх авсан зарим сургалтын байгууллагууд үндсэн баримтгүй, сургалтын арга хэмжээний хүрээнд бүрдүүлэх баримтын жагсаалтыг батлаагүй, санхүүгийн анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй зэргээр хууль тогтоомжийг зөрчсөн байна.

- **Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн дагуу олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хангалтгүй, зориулалт бусаар зарцуулсан, бизнес эрхлэх туршлага багатайгаас хөтөлбөр үр дүнд хүрэхгүйд хүрч байна.**

▪

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс төслийн явцын болон санхүүгийн, мөн төслийн эцсийн гүйцэтгэлийн тайлан авдаггүй, эргэн төлөлт хангалтгүй, хуваарийн дагуу төлөлт хийгддэггүй.

Төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, тухайлбал, тоног төхөөрөмж авах төсөл бичсэн атал бараа материал худалдан авсан баримт бүрдүүлсэн, санхүүгийн дэмжлэг олгох гэрээнд *"санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй бол буцаан төлүүлэх"* гэсэн заалт хэрэгждэггүй.

Хөтөлбөрт хамрагдаж бүлгийн зохион байгуулалтад орсон залуучууд эвлэлдэн нэгдэж, хамтран ажиллах туршлага дутмагаас санхүүгийн дэмжлэгийг хуваан авах талаар маргаан гарч улмаар тарах, төслийг үр дүнгүй болгоход хүргэдэг.

Хөтөлбөрт хамрагдах нас 15-24 гэж заасан, МСҮТ төгсөгч болон төгсөгчийн бүлгийн гишүүн нэг бүртэй гэрээ байгуулдаггүй, мөн бизнес эрхлэх туршлага багатай байгааг харгалзан эцэг эхийн оролцоог ханган батлан даагчаар оролцуулах эрх зүйн зохицуулалтгүйгээс эрсдэл гарч байна.

- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй санхүүжилтийг бууруулан олгосноос үндсэн зорилтоо хангаж чадахгүй байдалд хүргэж байна.**

▪

ХБИ-ийн төсөлийг шалгаруулж санхүүжилт олгохдоо Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.3.1-д заасан "нэг ажлын байранд 1.0 сая төгрөг..." гэснийг зөрчиж 1 иргэнд 500.0-800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгох байдлаар хэт хавтгайруулж олгосноос шалтгаалж хөтөлбөрийн үр дүнг үр ашиггүй болгож ажлын байр бий болгох үндсэн зорилтыг алдагдуулсан байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс гүйцэтгэлийн тайлан аваагүй тул гүйцэтгэлийн хяналт хийх боломжгүй, төслийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, "санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй бол буцаан төлүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, эргэн төлөлт хийх хуваарийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

- **Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй хөрөнгийн бүртгэл хангалтгүй, мэдээ тайлан хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.**

▪

Тус хөтөлбөр нь 2007 оноос өмнө туршилтаар зарим аймгуудад хэрэгжиж эхэлсэн гэх боловч тухайн онуудын тайлан мэдээ хангалтгүй, анх хэрэгжиж эхэлснээс хойш одоог хүртэл хэдэн малчинд хичнээн төгрөгийн санхүүжилт олгосон нь тодорхойгүй байна.

2007-2013 онуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих гэсэн зардлын зүйлээр нийт 18,705.2 сая төгрөгийг зарцуулсан гэх боловч яг малчдыг малжуулах хөтөлбөрт хэдэн төгрөгийн санхүүжилт олгож, ямар ямар аймаг, дүүргүүдэд хэнд, хэдэн төгрөгийг олгосон нь тодорхойгүй, салгаж үзэх боломжгүй байна.

2014-2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Санхүүжилт төлөвлөлтийн газраас өгсөн судалгаагаар 22,938.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, нийт үлдэгдэл 9,644.6 сая төгрөг байна гэж мэдээлсэн байхад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын мэргэжилтний гаргаж өгсөн судалгаагаар 23,964.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн мэт харагдаж байгаа нь төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт муу байгааг харуулж байна.

- **Цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй байна.**

Хөдөлмөрийн хувийн биржийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага бүртгэж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно./ 9.2 дахь заалт / "Хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний байгууллага байх бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаас бүрдэнэ" гэж заасны дагуу 2011 оноос эхлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн баазыг бүрдүүлэх зорилгоор жил бүрийн төсөвт тусгаж тодорхой хэмжээний хөрөнгийг зарцуулж ирсэн боловч мэдээллийн санг бүрдүүлж чадаагүй байна. Дээрх байдлаас шалтгаалж Сангийн мэдээллийн тоон үзүүлэлтийг аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд нэгтгэж тайлагнах үйл

ажиллагаа доголдсоноос шалтгаалж улсын хэмжээний дүн мэдээг үнэн зөв гаргах боломжгүй болсон байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж хяналт тавьж ажиллахгүй байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.4-д “Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн санд сангийн мэдээлэл нэгтгэх, программ хангамжийг боловсронгуй болгох, ажиллах горимыг зохицуулах, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах, аймаг нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх ажлыг хариуцна” заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

САНАЛ ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулахдаа “Төсвийн тухай хууль”-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын ХЭСангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өр авлагаа нэмэгдүүлсэн, халамжийн сангаас олгож байгаа санхүүжилтийн гүйцэтгэлийг бодит үр дүнтэй нь уялдуулан тооцож шинжилгээ дүгнэлт гаргаагүй, үнэт цаасны тооцоо болон сангийн хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, тооцоо нийлж актаар баталгаажуулдаггүйгээс анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтрийн тоон үзүүлэлт зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг зөрчил дутагдал илэрлээ

Төсвийн эрх захирагч нар Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсөл хөтөлбөр арга хэмжээний тоон мэдээллийг зөрүүтэй гаргасан, гэрээний эхлэх дуусах хугацааг тодорхой бичээгүй, гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож баталгаажуулаагүй зэргээр сангийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна. Шалгалтаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойноор доорхи холбогдох хууль, тогтоомж, журмыг зөрчсөн нийтлэг дутагдал гарч байна. Үүнд:

Төсвийг батлуулах, тодотголыг хийхдээ эдийн засгийн шинжилгээ судалгаа хийж өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнг тооцоогүй, нэгэнт батлагдсан хөтөлбөр арга хэмжээг тууштай хэрэгжүүлдэггүй жил бүр өөрчлөх байдлаар давхардсан олон жижиг арга хэмжээг төлөвлөж байгаа ч судалгаа хийж зайлшгүй шаардлагатай байгаа хөрөнгийн тооцоог гаргуулж төлөвлөсний үндсэн дээр зардлын эх үүсвэрийг батлуулахад анхаарч ажиллаагүй, өмнөх жилийн гүйцэтгэлд тулгуурлан төсвийг баталж ирсэн нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 30 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь, зарлага тооцох аргачлал” –ыг зөрчсөн байна.

Нийгмийн хамгааллын яамнаас харъяа байгууллагуудын төсвийг хянаж батлахдаа байгууллагын санал болгосон төсвийн төсөл, төсөл арга хэмжээний

зардлуудыг зориулалтын дагуу нарийвчилж баталдаггүй, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан төсөл арга хэмжээг санхүүжүүлэх байдлаар өмнөх жилийн гүйцэтгэлд тулгуурлан төсвийг баталж ирсэн нь Монгол улсын "Төсвийн тухай хууль"-ийн 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагна, 22.2.3. эдийн засгийн ангиллаар; 22.2.4 хөтөлбөрөөр; 22.2.5.арга хэмжээгээр ангилна гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах, орлого тасарч байгаа шалтгааныг судлан, төлөвлөлтийг оновчтой болгох талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Тус газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны тайланд хийсэн санхүүгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжид тусгагдсан "Төсвийн тухай" хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал: Сангийн хөрөнгө төвлөрүүлэлт 2013 онд 7.9 тэрбум төгрөгөөр тасалдсан, аж ахуйн нэгж, байгууллагууд Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолд заасан "Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийг сар бүр төлөх" заалтыг мөрдөж ажиллаагүйгээс ойролцоогоор 3 тэрбум төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлээгүй,

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл нь орлого, зарлагын байдалд хяналт тавих нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй, дотоод хяналт шалгалтыг хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох үнэлэх талаас нь хангалттай ажил зохион байгуулаагүй, ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй, зохион байгуулж байгаа арга хэмжээ, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр нь богино хугацааны, түр зуурын шинж чанартай, үйлдвэрлэл дээрх сургалт, эрхийн бичгийн сургалт болон богино хэмжээний сургалт, нийтийн хамарсан ажлын хүрээнд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч үр нөлөө нь хангалтгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу аймаг, нийслэл дүүргийн ХХҮГ-ын ХЭДСангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор доорхи холбогдох хууль, тогтоомж, журмыг зөрчсөн, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг бүрэн барагдуулаагүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн байна

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд Мэргэжлийн чиг баримжаа олгох, Хөдөлмөрт бэлтгэх, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээнд 885,829 хүнийг хамруулж 17.9 тэрбум төгрөг, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /ажлын байр дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг хөтөлбөр, арга хэмжээнд 285,202 хүнийг хамруулж 77.1 тэрбум төгрөг зарцуулсан зэрэг Засгийн газраас тодорхойлсон зорилтот ажлуудыг хэрэгжүүлж ажилласан боловч санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой их хэмжээний зөрчил дутагдал илэрлээ.

- Байгууллагын үйл ажиллагаа, халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд өмнөх онуудад хийсэн шалгалтаар нийт 24,9 тэрбум төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 1,093.0 сая төгрөгийн зөрчилд улсын /ахлах/ байцаагчийн 132 акт, 23,843.3 сая төгрөгийн зөрчилд хугацаатай 47 албан шаардлага өгсөнд дүгнэлт хийж системийн хэмжээнд гарсан алдаа, зөрчил дутагдалыг засаж залруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

- Үүнээс аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудад 2017 онд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэсээс хийсэн хяналт, шалгалтаар нийт 905.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 448.6 сая төгрөгийн зөрчилд улсын /ахлах/ байцаагчийн 53 акт, 456.9 сая төгрөгийн зөрчилд 16 хугацаатай албан шаардлага өгсөн байна. Илэрсэн зөрчлийн дийлэнх буюу 46.4 хувийг зориулалт бусаар зарцуулсан, 34.1 хувийг үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй, 14.5 хувийг бусад, 3.9 хувийг бусдад зээлдүүлж, түр ашиглуулсан зэрэг зөрчил тус тус эзэлж байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд 439.3 сая төгрөгийн улсын байцаагчийн 2 акт, дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Үйлдвэр худалдааны яаманд зээлдүүлсэн 21.4 тэрбум төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 1 албан шаардлага хүргүүлсэн боловч гүйцэтгэл үр дүнг тооцож албан шаардлагаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай Засгийн газрын 2014 оны 147, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон, нийслэл, орон нутгийн зөвлөлийн шийдвэрээр олгосон буцалтгүй тэтгэмж тусламжинд 5.5 тэрбум төгрөгийг олгосон нь Монгол улсын Төсвийн тухай, ТБОНӨАҮХАТухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

- Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111 дүгээр зүйлийн 111.1-т “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна”, 111.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө”, Засгийн Газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөр” нь тус сангийн орлогын эх үүсвэр болох боловч системийн хэмжээгээр энэ орлогыг төвлөрүүлэх судалгаа, гүйцэтгэл дээр огт анхаардаггүй, орлогын төлөвлөгөөнд маш бага хэмжээгээр тусгаж ирсэн байна.

- Хуулинд заагдсан дээрх заалтуудыг бүх аж ахуйн нэгжүүдийг хамруулан хэрэгжүүлж чадвал, нэгдүгээрт сангийн орлого нэмэгдэх, хоёрдугаарт хөгжлийн

бэрхшээлтэй, одой хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэх боломжтой байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэлд дотоодын хяналт шалгалт хийхдээ бодит гүйцэтгэлд үнэлгээ дүгнэлт өгдөггүй, зөвхөн хөтөлбөрт шаардлагатай баримт бичгийн бүрдэлд хяналт үнэлгээ хийж, санхүүгийн эрхийг олгож ажилласан нь зөрчил гарах шалтгаан болсон байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийн хүү банкны зээлийн хүүгээс ихээхэн доогуур байгаа тул арилжааны банкууд зээлийн эх үүсвэрийг урт хугацаагаар банкиндаа байршуулж, банкны бусад үйл ажиллагаанд ашиглан, ашиг олж байна.

- Тухайлбал, Капитал банкинд шилжүүлсэн 7.0 тэрбум төгрөгөөс уг гэрээний 3.15-д заасны дагуу 6 сарын дотор эх үүсвэрийг бүрэн зээл хэлбэрээр олгохыг заасан байтал гэрээний заасан хугацаанд 4.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй буюу зээлийн эх үүсвэрээс 31.8 хувь нь олгогдсон байна. Зээл хэлбэрээр олгогдоогүй хөрөнгийн эх үүсвэр нь 2,389 хүнийг ажлын тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй болгох, 954 өрхийг малжуулах боломж байсныг алдсан байна.

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, АШИГЛАЛТЫН ТАЛААР

Хөдөлмөрийн хувийн биржийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага бүртгэж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно./ 9.2 дахь заалт /Хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний байгууллага байх бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон төрийн , төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаас бүрдэнэ гэж заасны дагуу 2011 оноос эхлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн баазыг бүрдүүлэх зорилгоор жил бүрийн төсөвт тусгаж тодорхой хэмжээний хөрөнгийг зарцуулж ирсэн боловч мэдээллийн санг бүрдүүлж чадаагүй байна. Дээрх байдлаас шалтгаалж Сангийн мэдээллийн тоон үзүүлэлтийг аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд нэгтгэж тайлагнах үйл ажиллагаа доголдоноос шалтгаалж улсын хэмжээний дүн мэдээг үнэн зөв гаргах боломжгүй болсон байна.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.-д Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.2 “төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар санал боловсруулах, хэлэлцэх, энэ хуулийн 6.3.1-6.3.4, 6.3.6-д заасан төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах” гэсний дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг баталсан байна. Тухайлбал:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг батлахдаа уг хөтөлбөрийн 5.1-т “,, хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор бүлэгт 10 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно.” гэж баталсан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно” гэсэн заалтыг зөрчжээ.

2017-2018 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт улсын хэмжээгээр нийтдээ 2,545.9 сая төгрөгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосоноос 2,239.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд 2012-2017 онд Сангийн яам, Үндэсний аудитын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас хийсэн хяналт шалгалтын дүнгээс харахад:

Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байрыг дэмжих, Аж ахуй эрхлэлтийн бичил бизнесийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүд цаашид хэрэгжих бүрэн боломжтой хэдий ч анхан шатанд хэрэгжүүлэхэд нэлээдгүй зөрчил дутагдал илэрсэн байна.

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015.12.16-ны өдрийн 9 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгасан дүнгээс харахад:
- Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Аж ахуй эрхлэлтийн бичил бизнесийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байгаа нь төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээнд заасан "төслийн үйл ажиллагааны тайланг сар бүр гаргаж, санхүүгийн баримттай ирүүлнэ" гэснийг зөрчсөн байна.
- **Аж ахуй, бичил бизнес эрхлэгчид эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний дагуу** Жижиг зээл банкаар дамжин олгогдож байгаа тул банкны шалгуур өндөр байгаагаас хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд хамрагдаж чадахгүй сөрөг үр дагавар гарсан байна .
- Аж ахуй эрхлэлтийн сургалтыг орон нутгийн харъяалалгүй гадны байгууллага зохион байгуулж явуулж байгаагаас шалтгаалж сургалтын чанар муу, богино хугацаанд хичээллэж эргэх холбоогүй байгаагаас шалтгаалж гүйцэтгэл үр дүн, бодитой тооцогдоггүй,
- Мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөр, модулиас шалтгаалан сургалтын үргэлжлэх хугацааны талаар тодорхой мэдээлэл хөтөлбөрт болон удирдамжинд тусгагдаж ирдэггүйгээс сургалтын үргэлжлэх хугацаа тодорхойгүй, мэргэжилт-нүүдийг чадавхижуулах сургалтад энэ талаар мэдээлээгүй, сургалтад хамрагдаж буй иргэдийг чадавхижуулах, мэргэшүүлэх талаар Бизнес инкубацийн үйлчилгээ орон нутагт байдаггүйгээс сургалт үр дүнгүй болж хөрөнгө мөнгийг үр ашиггүй зарцуулах үндэслэл болж байна.

- Сургалтын эрх авсан зарим сургалтын байгууллагууд үндсэн баримтгүй, сургалтын арга хэмжээний хүрээнд бүрдүүлэх баримтын жагсаалтыг батлаагүй, санхүүгийн анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй зэргээр хууль тогтоомжийг зөрчсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

ХБИ-ийн төсөл шалгаруулж санхүүжилт олгохдоо Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.3.1-д заасан "нэг ажлын байранд 1,0 сая төгрөг..." гэснийг зөрчиж 1 иргэнд 500.0-800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгох байдлаар хэт хавтгайруулж олгосноос шалтгаалж хөтөлбөрийн үр дүнг үр ашиггүй болгож ажлын байр бий болгох үндсэн зорилтыг алдагдуулсан байна.

Мөн дээрх хөтөлбөрийн хүрээнд 3.3.1-д заасан "нэг ажлын байранд 1.0 сая төгрөг..." гэснийг зөрчиж 1 иргэнд 1.0 сая дээш төгрөгийн санхүүжилт олгосон нь ашиг сонирхолын зөрчил үүсгэсэн гэж үзэх үндэслэлтэй байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн ирүүлсэн төслийг шалгаж үзэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэдэн төгрөгний дэмжлэг хүссэн нь тодорхойгүй төслийг шалгаруулсан,

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс гүйцэтгэлийн тайлан аваагүй тул гүйцэтгэлийн хяналт хийх боломжгүй, төслийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй бол буцаан төлүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй зэргээр " Аж ахуй, бичил бизнес эрхлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэний эргэн төлөлтэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 3.5-д "санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж хавсралтад тусгагдсан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө", 2.3-д "Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, хавсралтад тусгагдсан Б талын боловсруулсан Эргэн төлөлт хийх хуваарийн биелэлтэд хяналт тавьж ажиллана" гэснийг тус тус зөрчсөн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хийгдсэн гурван талт гэрээнүүд дугаарлалт хийгдээгүй, В талын эрх үүрэгт малын тоог бичээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна.
- Дээрх хөтөлбөрүүдээр санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн төслийн гүйцэтгэлийн тайлан байхгүйгээс төсөлд тусгагдсан бараа, материал, тоног төхөөрөмж худалдан авсан эсэхийг нягтлан шалгах боломжгүй байдлаас шалтгаалж төслийн зориулалтыг өөрчлөх зэрэг нийтлэг зөрчил дутагдал гарчээ.
- Төслийн хэрэгжилтийн байдлаас дүгнэж үзэхэд: үр дүн, үр нөлөө багатай үр ашиггүй төслүүдийг сонгон шалгаруулж санхүүжүүлсэн нь дээрх арга хэмжээнээс харагдаж байна..
- Энэ нь Хөдөлмөрийн хэлтсийн /хуучнаар/ гэрээний хэрэгжилтийг хангуулдаггүй, ажил хариуцсан албан тушаалтнуудын хариуцлага сул дотоод хяналтын

зардалд 70-аас доошгүй хувийг зарцуулсан атлаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтэнд огт хийгдээгүй байгаа нь батлагдсан хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна.

Жижиг зээлийн талаар:

1. Капитал банкинд байршуулсан 7.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хугацаанд нь буцаан төвлөрүүлээгүй, хугацаа хэтрүүлсэний алданги тооцож төлүүлээгүй байна.

Хөдөлмөрийн сайд болон Капитал банк хооронд 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 2015/65 5/342 дугаартай гэрээг байгуулж, жижиг зээл олгоход зориулж 7.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр банкинд байршуулсан байна. Гэрээний хугацаа 2018 оны 3 дугаар сарын 23-нд дуусч, эх үүсвэрийг буцаан төвлөрүүлэх ёстой байсан хэдий ч одоог хүртэл төвлөрүүлээгүй байна.

ХЭДС-гийн ажилтнууд эх үүсвэрийг буцаан татах талаар удаа дараа банкны удирдлагуудад мэдэгдэж, албан бичиг хүргүүлсэн боловч банкны зүгээс гэрээний үүргээ зөрчиж гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.1 хувийн алданги тооцох ёстой бөгөөд уг төлбөрийг төлүүлээгүй байна.

Дээрх эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй, зээлд ашигласан дүн нь 3.58 тэрбум төгрөг буюу 51.1 хувь байгаа нь үлдэх эх үүсвэрийг банк зориулалт бусаар ашигласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн зээлийн эх үүсвэрийг гэрээний дагуу 6 сарын дотор бүрэн зээлд гаргаж дуусгах, үүнээс хойш ашиглаагүй эх үүсвэрт сарын 0.3 хувийн алданги тооцохоор заасаг боловч ХЭДС-нд төлөх ёстой алдангийг тооцоож төлүүлээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж үйлдэж тооцоо хийж баталгаажуулаагүй байна. Тооцоогоор эх үүсвэр зээлд гараагүй алданги, хугацаа хоцроосон алданги нийт 1.7 тэрбум төгрөг төлүүлэх шаардлагатай.

2. Дампуурсан “Анод” банк болон “Дэлгэр Экспресс” ББСБ-аас авах найдваргүй авлагын үлдэгдэл 847.5 сая төгрөгийн балансад бүртгэлтэй байна. 2005-2008 онд Анод банкаар дамжуулан ХЭДСан нь жижиг зээл олгож байсан бөгөөд тус банк татан буугдсанаар 2008 онд байршуулсан эх үүсвэрийн үлдэгдэл 800 сая төгрөг буцаан төвлөрүүлээгүй байна.

Мөн Дэлгэр Экспресс ББСБ-аар дамжуулан олгож байсан жижиг зээлийн эх үүсвэр 47.5 сая төгрөгийг буцаан татан төвлөрүүлээгүй найдваргүй авлага хэлбэрээр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Тухайн үед ХХҮГ-аас Хаан, Хас банкинд албан тоот хүргүүлж (2009 оны 1/1607, 1/1627) Анод банкинд байршуулсан эх үүсвэрээс олгосон зээлийн үлдэгдэл шилжүүлэхээр хамтран ажиллах санал хүргүүлж байсан бөгөөд Хаан банк хүлээж аваагүй, Хасбанкны зүгээс 2009 оны 4/3441 албан тоот бичгээр шилжүүлэн авах асуудлыг зээлийг судалсны үндсэн дээр авахаар хариу ирүүлсэн байна. Хасбанкны 2009 оны 4/3725 тоот албан бичгээр зээлийн үлдэгдлийн судалгаа гаргаж, шилжүүлэн авах боломжгүй талаар мэдэгдсэн байна.

3. Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын дагуу ХЭДС-гаас олгосон 17.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн эргэн төлөлт хангалтгүй, хуульд заасан зардлын ангилалаас гаргаагүй, Сангийн яамны 2017 оны шалгалтын ажлын хэсгээс гаргасан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Уг тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн дүрэмт хувцыг үндэсний үйлдвэрүүдээс нийлүүлэх зорилгоор Хөдөлмөрийн яам болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /хуучин нэрээр/-ны хооронд Дамжуулан зээлдүүлэх гэрээ" байгуулж, Оёдлын нэгдсэн холбоо ТББ-д ХЭДС-гаас 17.0 тэрбум төгрөг олгосон нь Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан "Жижиг зээлийг зөвхөн банкаар дамжуулан олгох" -оор заасан журмыг зөрчсөн байна.

Мөн уг эх үүсвэрийг гаргахдаа хуульд заасан зардлын төрлөөр бус тухайн оны жижиг зээлд батлагдсан төсвөөс зарцуулсан байна. Оёдлын нэгдсэн холбоо ТББ-д олгосон зээлийн эргэн төлөлт 1,180.1 сая төгрөг төлж, 15,819.9 сая төгрөгийн үндсэн зээл төлөгдөөгүй байна. Сангийн яамны СХЭУГ-аас 2017 онд ХЭДС-гийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтээр уг зээлтэй холбоотой үндсэн зээлийн үлдэгдэл, хүү болон алдангийн төлбөр болох нийт 18.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулж зээлийг улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн боловч биелэлт үр дүн хангалтгүй байна.

4. Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/152 дугаар тушаалаар жижиг зээлийн эх үүсвэрийг аймаг, дүүргийн дэд сангуудад хуваарилсан ба арилжааны банкуудтай гэрээ байгуулсан байна. Эдгээр оролцогч банкуудын сонгон шалгаруулалт явагдсан эсэх, талаар холбогдох баримт байхгүй байна.

Оролцогч банкууд болох Хас, Хаан, Капитал, Төрийн банкуудтай Хөдөлмөрийн сайд болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсийн дарга нарын хооронд гэрээ байгуулсан боловч эдгээр банкуудыг хэрхэн сонгон шалгаруулсан эсэх талаар баримт материал хангалтгүй байна.

5. 2014 онд жижиг зээлийн эх үүсвэр байршуулахдаа банкны сонгон шалгаруулалтыг хийгээгүй шууд гэрээ байгуулсан байна. Хөдөлмөрийн сайд болон Төрийн банкны Гүйцэтгэх захирлын хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 5/2013/16/676 дугаар жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх гэрээг байгуулсан ба ингэхдээ жижиг зээлийн журмын дагуу банк сонгон шалгаруулаагүй, Төрийн банктэй шууд гэрээ байгуулан 17.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байршуулсан байна.

6. Жижиг зээлийн ашиглалт хангалтгүй, түүнд тавих хяналт сул байна. Жижиг зээл олгож буй банкуудтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээнд ХХҮЕГ зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавихаар заасан ч хэрэгжилт хангалтгүй, зээлийн ашиглалтад тавих хяналт сул байна. Мөн Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын 6.5-д зааснаар аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хяналт, шалгалт хийж жижиг зээлийн эх үүсвэрийн ашиглалт, зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих байдал хангалтгүй байна.

7. Жижиг зээлтэй холбоотой нэгдсэн мэдээллийн бааз дутмаг, өмнөх онуудын мэдээлэл хангалтгүй, мэдээллийн хадгалалт, шилжүүлэлт, ажлын залгамж холбоо сул байна. ХХҮЕГ-т ХЭДС-гийн ерөнхий нягтлан бодогч болон хариуцсан нэг мэргэжилтэн ажилладаг бөгөөд жижиг зээлтэй холбоотой нэгдсэн мэдээлэл хангалтгүй байна. ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн газар шинээр ажлын байр үүсгэж байгаа болон хадгалагдан үлдэж байгаа ажлын байрны тоо, судалгааг

гаргадаг бөгөөд жижиг зээлтэй холбоотой олгосон зээл, эргэн төлөлтийн мэдээлэл дутмаг байна.

8.ХНХСайдын албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу сонгон шалгарсан банктай дамжуулан зээлдүүлэх гэрээг ХХҮЕГ-ын дарга байгуулан, эх үүсвэрт байршуулах хөрөнгийг бөөн дүнгээр банкинд шилжүүлж байна. Зээлийн эх үүсвэрийг бөөн дүнгээр байршуулснаар ашиглалт хангалтгүй байх, зориулалт бусаар ашиглах эрсдэл үүсгэж байна. Гэрээнд банк нь эх үүсвэр шилжүүлэн авснаас хойш 6 сарын дотор жижиг зээлийг зээлдэгчдэд бүрэн гаргаж ажиллахаар заасан. Мөн зээлд ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэлд жилийн 3.0 хувийн хүү тооцож улирал бүр төлөхөөр заасан байна. Гэсэн ч 6 сарын хугацаанд багтаан зээлийг бүрэн гаргаж чадахгүй байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР